

“Монголын түүхэн дэх Богд гэгээнтний институт” өгүүллийн эмхэтгэл Москвад хэвлэгдэв

ОХУ-ын Шинжлэх Ухааны Академи, Дорнодахины хүрээлэнгийн цуврал бүтээлийн 25 дугаар ботид Богд хааны мэндэлсний 150 жилийн ойд зориулан ОХУ-ын Шинжлэх Ухааны Академийн Дорнодахины хүрээлэн, Монгол Улсын ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн хамтран Москва хотноо орос хэлээр “ИНСТИТУТ БОГДО-ГЭГЭНА В ИСТОРИИ МОНГОЛИИ. К 150-летию Богдо-гэгэна Джебцзундамба-хутухты VIII – Последнего Великого хана Монголов” хэмээсэн нэртэй өгүүллийн эмхэтгэл хэвлүүлжээ.

Хариуцлагатай редактор: Кузьмин Сергей Львович, Оохнойн Батсайхан

Шүүмжлэгч: Орлова Кеemia Владимировна (ИВРАН), Алтай Дулбаа (ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн)

ISBN: 978-5-89282-908-3

Энэхүү 484 хуудастай хамтарсан эмхэтгэлд Оросын Холбооны Улсын ШУА-ийн Дорнодахины хүрээлэнгийн доктор, профессор С.Л.Кузьмин нарын эрдэмтэд, Монгол Улсын ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн доктор, профессор О.Батсайхан, МУИС-ийн профессор З.Лонжид нарын эрдэмтэд, Японы Шимоносеки хотын их сургуулийн профессор Тачибана Макото, Токиогийн Гадаад судлалын их сургуулийн профессор Аоки Масахиро нарын, Их Британий эрдэмтэн С.Бирн нарын нийтдээ 33 монголч эрдэмтдний бичсэн өгүүллийг багтаасан байна.

2019 онд Орчин үеийн Монгол Улсын үндэс суурийг тавьсан, монголчуудын сүүлчийн эзэн хаан VIII Богд гэгээн Жавзандамба

хутагтын мэндэлсний 150 жилийн ой тохиож байна. Энэхүү өгүүллийн эмхэтгэл нь Монгол Улсын хаан VIII Богд гэгээний институцтэй холбогдол бүхий түүх, улс төр, шашин ба соёл судлалын талаарх бүтээлүүдийг багтаасан болно. Өгүүллийн зохиогчид нь Орос, Монгол, Япон, Их Британи, Польш ба Казахстан улсуудад тухайн шинжлэх ухааны салбарт нэр алдар хүлээсэн, уг асуудлаар дагнан судалгаа хийж буй эрдэмтэн, судлаачид болно. Энэхүү баримт бичгийн эмхэтгэлийн цахим хувилбарыг доорх сайтаас татаж авч үзэж болно.

<http://book.ivran.ru/book?id=1468> - рус.

<http://book.ivran.ru/en-book?id=1468> - англ.

<http://book.ivran.ru/f/bogdgegeen-institution-in-the-history-of-mongolia.pdf> - PDF

Мэдээ бэлтгэсэн:

*Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан,
доктор (Sc.D), профессор Оохнойн Батсайхан*